



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР**

*Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан*



**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГИЙН ОРЛОГЫН
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот
2014 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар		Товчилсон үгийн жагсаалт	2
Дарга	Б.Алтанзул	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
Аудитын менежер	З.Ариунзаяа	Ерөнхий мэдээлэл	4
Аудитор Шинжээч	Ц.Эрдэнэчулуун Л.Нямтөмөр	Бүлэг 1. Хүний хөгжил сангийн хөрөнгийг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөөгүй байна	6
		▪ Хүний хөгжил сангийн орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй байна	6
		▪ Хүний хөгжил сангийн орлогын бүрдүүлэлт хуулийн дагуу бүрэн төвлөрөөгүй байна	8
		▪ Зарим арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд олгох хүүгийн орлогын төвлөрүүлэлт зохих журмын дагуу хийгдээгүй байна	9
		Бүлэг 2. Хүний хөгжил сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан байна	10
		▪ Иргэдэд олгосон хишиг хувийг илүү бодитой, үр дүнтэй зүйлд зарцуулж болох байжээ	11
		▪ Сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан зохих журмын дагуу зарцуулсан байна	12
		Бүлэг 3. Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хийжээ	13
2014 оны 5 дугаар сар		Дүгнэлт	15
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.		Холбогдох байгууллагын санал	16
www.audit.mn		Зөвлөмж	17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.		Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	18
ХАЯГ:			
Үндэсний аудитын газар			
210642 Чингэлтэй дүүрэг,			
Засгийн газрын 4 дүгээр байр,			
Бага тойруу-6, Улаанбаатар-46			
Монгол Улс			

Товчилсон үгийн жагсаалт

АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БЗД	Баянзүрх дүүрэг
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НХХЯ	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам (хуучнаар)
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НХҮЕГ	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар
НХҮХ	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ӨННАТ	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮЦТТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТСГ	Төрийн сангийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ХК	Хувьцаат компани
ХҮХ	Халамж үйлчилгээний хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоол, ҮАГ-аас МУ-ын Ерөнхий Аудитор 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Хүний хөгжил сангийн үйл ажиллагаа хуулийн дагуу үр дүнтэй явагдаж байгаа эсэхэд дараах зорилтын хүрээнд авч үзэв. Үүнд:

1. Хүний хөгжил сангийн мөнгөн хөрөнгийн бүрдүүлэлтийг хууль тогтоомжтой уялдуулан бодитой төлөвлөсөн эсэх;
2. Сангийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж байгаа эсэх;
3. Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитаар СЯ, ХАХНХЯ, НХҮЕГ, нийслэлийн СХД, БЗД, СБД болон аймгийн НХҮХ зэрэг байгууллагуудын Хүний хөгжил сангийн 2013 оны үйл ажиллагаа, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн төлөвлөлт, түүний гүйцэтгэл, Хүний хөгжил сангийн хуулийн хэрэгжилт, Хүний хөгжил сангаас иргэн бүрт хишиг хувь хүртээх хөрөнгийн гүйцэтгэл, хувьцаа олголтын байдлыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, баримт материалд судалгаа хийж, хариуцсан албан тушаалтнуудаас ярилцлага, асуулга лавлагаа, тодруулга авч, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт өглөө.

Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Хүний хөгжил сангийн тухай хууль
- Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт

Ерөнхий мэдээлэл

Улсын Их хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Стратегийн томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрд 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлэх”-ээр заасан байна.

УИХ-аас ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээхээр Монгол Улсын “Хүний хөгжил сангийн тухай хууль”-ийг 2009 оны 11 дүгээр сарын 18-нд батлан хэрэгжүүлсэн байна.

“Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 84 дүгээр тогтоол гарч 1.5 сая төгрөгөөс 500.0 мянган төгрөгийг 2010-2012 онд бэлнээр олгохоор шийдвэрлэж, иргэн бүрт 2010 онд 120.0 мянган төгрөг, 2011 онд сар бүр 21.0 мянган төгрөг буюу нийт 252.0 мянган төгрөг, 2012 оны эхний 6 сард нийт 128.0 мянган төгрөгийг олгосноос 500.0 мянган төгрөгийн хувь хишгийг Сангийн яам, НХХЯ-наас (хуучнаар) ХААН, Хадгаламж, Капитал, Хас банктэй гэрээ байгуулан олгосон байна.

Дээрх хувь хишгээс 500.0 мянган төгрөгийг иргэн бүрт 2010-2012 онуудад бэлнээр олгож үлдэж буй 1.0 сая төгрөгийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эсвэл бэлэн мөнгөний гэсэн сонголттойгоор олгохоор ЗГ-аас чиглэл гаргаж “...Хүний хөгжил сангийн 2012 оны Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, УИХ-ын 2011 оны 57 дугаар тогтоолоор иргэн бүрд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 1.0 сая төгрөгтэй тэнцэх нэрлэсэн үнэ бүхий хувьцааг иргэн бүрт эзэмшүүлэх асуудлыг 2012 оны 2 дугаар сарын 1-ний хугацаанд шийдвэрлэхийг Засгийн газарт даалгажээ.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 98 дугаар тогтоолд зааснаар 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэн бүр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 536 ширхэг хувьцааг нэг удаа үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхээр болсон байна. Үүний дараагаар Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоолоор “Иргэдэд тус компанийн 536 ширхэг хувьцаа нэмж эзэмшүүлэх болон 2011 оны 4 дүгээр сарын 1-ээс 2012 оны 4 дүгээр сарын 11-ний хооронд төрсөн МУ-ын иргэнд тус компанийн 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх”-ээр шийдвэрлэжээ.

ЗГ-ын 2012 оны 116 дугаар тогтоолоор Монгол Улсын иргэн хувьцаагаар авах эсвэл дараах тохиолдолд 1.0 сая төгрөгнөөс суутгуулж бэлнээр авах эрх нээгдсэн байна. Үүнд:

- Хүний хөгжил сангаас хишиг, хувийг бэлэн мөнгөөр авах хүсэлт гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
- 2010-2011, 2011-2012 оны хичээлийн жилд сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртсэн оюутан /нэг жилийнх 500.0 мянган төгрөг/,
- 2011 онд эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хишиг, хувь хүртсэн иргэн.

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй БДК /брокер, дилерийн компани/-д хандаж дараах үе шатын дагуу гэрээ байгуулж, дансандаа холбогдох бичилтийг хийлгэхээр болсон байна.

Иргэн “Эрдэнэс тавантолгой” ХК-ний хувьцааны эзэмшлээ дараах үе шатаар дамжин бүртгүүлдэг байна.



ЗГ-ын 2010 оны 350 дугаар тогтоолоор “МУ-ын иргэнд эзэмшүүлсэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааг түүний 2 дахь зах зээл нээгдэх хүртэл бусдад зарах, шилжүүлэхгүй байх” тухай заажээ.

Монгол Улсын иргэдэд ногдох “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 20 хувь болох 3.0 тэрбум ширхэг хувьцааг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө төрсөн, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэдэд тэнцүү хуваан үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхээр шийдвэрлэж, ҮЦТГТХТ-д 2.834.837 Монгол Улсын иргэнд хувьцаа эзэмшүүлэхээр бичилт хийсэн бөгөөд үүнээс дансаа нээлгэсэн 524.291 иргэн байна.

Дээрх 524.291 иргэнд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 98 дугаар тогтоолын дагуу 536 ширхэг хувьцааг холбогдох дансанд нь шилжүүлж, Засгийн газрын 2012 оны 116 дугаар тогтоолын дагуу нэмж олгохоор болсон 536 ширхэг хувьцааны бүртгэлийг ХХҮГ-аас ирэх хүсэлтийн дагуу нэмж бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Хүний хөгжил санд 2010-2013 онд нийт 1,306.9 тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж, 2,229.9 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, зөрүү 923.0 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөөр 139.9 тэрбум, урьдчилгаа төлбөрөөр 522.4 тэрбум, ЗГ-ын бондоор 260.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлжээ.

Тус сан 2013 оны хувьд АМНАТ-өөс 195.9 тэрбум, ӨННАТ-өөс 129.1 тэрбум, хувьцааны ногдол ашгаас 68.3 тэрбум, хүүгийн орлогоос 0.2 тэрбум нийт 393.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төр хариуцах ЭМД-ын шимтгэлд 12.1 тэрбум, 0-18 насны хүүхдэд олгох мөнгөнд 228.9 тэрбум, өмнөх онд олгосон бэлэн мөнгөө аваагүй иргэдэд 28.6 тэрбум, ЗГ-ын зээл, бондын хүүд 8.5 тэрбум, нийт 278.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

**БҮЛЭГ 1. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ
УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА**

1.1 Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Сангийн хөрөнгийн ерөнхий удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Сангийн хөрөнгийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байна.

**Хүний хөгжил сангийн орлогын эх үүсвэрийг
бодитой төлөвлөөгүй байна**

1.2 Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөөнд уул уурхайн салбарын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тасарсанаас сар бүр хүүхдийн мөнгө олгоход эх үүсвэр дутагдаж, санхүүжилтийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.7¹-д заасныг баримтлан улсын төсөвт 148.4 тэрбум төгрөгийн өглөг үүсгэж Хүний хөгжил сангийн зарлагыг санхүүжүүлсэн байна.

1.3 “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай” хуулийг хэрэгжүүлэх явцад үүсч болзошгүй эрсдэл, орлогын эх үүсвэрийн дутагдлыг урьдчилан тооцоогүйгээс, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөөг эхний 9 сарын байдлаар 86.7 тэрбум төгрөгөөр тасалсан байна. МУ-ын ЗГ-аас Оюу Толгойн гэрээнд өөрчлөлт оруулсанаар төвлөрөхөөр тооцсон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн 154.9 тэрбум төгрөгийн орлого төсөвт төвлөрөөгүй зэрэг шалтгаанаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2013 оны нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал ДНБ-ний 6.8 хувьд хүрэхээр СЯ-наас тооцоо гарсан тул Засгийн газар Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2² дугаар зүйлийг үндэслэн төсвийн тодотголын төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлснээр, Хүний хөгжил сангийн 2013 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлагджээ.

1.4 “Хүний хөгжил сангийн 2013 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар тус сангийн нийт орлого, эх үүсвэр 397.5 тэрбум төгрөг, нийт зарлага 282.8 тэрбум төгрөг байхаар батлагдсан байна.

1.5 Монгол Улсын Их хурлын 2009 оны “Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” 22 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны “Суутган тооцох тухай” 172 дугаар тогтоолын дагуу Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн төлөвлөгөөгөөр урьдчилгаа төлбөрийг хаахад нийт 62.4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 76.5 тэрбум төгрөг буюу “Оюу Толгой” ХХК-ийн урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл төлбөрөөс тус компанийн татварын өрийг суутгах байдлаар нийт 40.6 тэрбум төгрөг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн татварын 35.9 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг урьдчилгаа төлбөрөөс суутган тооцож бууруулсан байна.

1.6 Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4³-т заасны дагуу Хүний хөгжил сангийн орлого, зарлагын зөрүүг нөхөх зориулалтаар Хүний хөгжил сангийн төсвийн сар, улирлын чанартай алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Хүний

¹ “Улсын төсөв болон Хүний хөгжил сангийн төсвийн зарлагыг тогтмол хугацаанд санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг төрийн сангийн нэгдсэн дансны хүрээнд улсын төсөв болон улсын төсвийн ерөнхийлөн захирагчид тухайн жилийн эцэст хаагдсан байхаар мөнгөн хөрөнгийн өглөг үүсгэн бүрдүүлэх”

² “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх”

³ Сангийн тухайн жилийн төсвийн алдагдлыг Засгийн газрын бонд, өрийн бичиг, зээл, үнэт цаас гарган санхүүжүүлж үндсэн болон хүүгийн төлбөрийг сангаас төлж болно.

хөгжил сангийн тухай хууль, УИХ-ын 2013 оны 57 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны 256 дугаар тушаалын дагуу 55.6 тэрбум төгрөгийн богино хугацаат Засгийн газрын үнэт цаасыг арилжааны банкуудад арилжаалж, Хүний хөгжил сангийн зарлага санхүүжилтийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

1.7 Засгийн газрын үнэт цаас арилжсаны орлогын эх үүсвэрийг УИХ-ын 2012 оны “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” 64 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 273 дугаар тушаалын дагуу НДЕГ-аас жилийн 8 хувийн хүүтэйгээр 108.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

1.8 Улсын Их Хурлаас “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль”, “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар батлагдсан Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн орлого, зарлагын эх үүсвэрийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүний хөгжил сангийн 2013 оны тодотгосон төсөв

(сая төгрөг)

1. Нийт орлого		397,580.8
1.1.	Хүний хөгжил сангийн тухай хууль (ХХСТХ)-ийн 3.2.1-д заасан орлого (Ногдол ашиг, хувьцаа борлуулсан орлого)	68,305.6
1.2.	ХХСТХ-ийн 3.2.2-д заасан орлого (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг)	329,275.2
1.3.	ХХСТХ-ийн 3.2.3-д заасан орлого (Хөрөнгө оруулалтын цэвэр ашиг)	0.0
2. Нийт зарлага		282,799.5
2.1.	Тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт	12,151.5
	2.1.1. ЭМД-ын шимтгэл	12,151.5
2.2.	Бэлэн мөнгө	262,000.0
	2.2.1. Хүүхдэд олгох мөнгө	234,000.0
	2.2.2. Сар бүр олгох 21 мянган төгрөг	28,000.0
2.3.	Зээлийн үйлчилгээний төлбөр	8,648.0
3. Ашиг, алдагдал		114,781.3
4. Алдагдалыг санхүүжүүлэх эх үүсвэр		-114,781.3
4.1.	Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	0.0
4.2.	ХХСТХ-ийн 3.2.4-д заасан эх үүсвэр (Урьдчилгаа төлбөр)	-62,397.0
4.3.	Засгийн газрын бонд	-52,384.3
	4.3.1. Шинээр гаргах	55,715.7
	4.3.2. Үндсэн төлбөр	-108,100.0

1.9 Улсын Их Хурлаас Хүний хөгжил сангийн төсөвт 2013 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн орлогын хэмжээг 621.4 тэрбум төгрөгөөр, зарлагыг 284.1 тэрбум төгрөгөөр баталсан⁴ боловч, Хүний хөгжил сангийн 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар орлогыг оны эхэнд төлөвлөсөн хэмжээнээс 223.8 тэрбум төгрөгөөр бууруулж, эх үүсвэр 397.6 тэрбум төгрөгөөр, зарлагыг 282.8 тэрбум төгрөгөөр тус тус баталсан нь сангийн орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөгөөгүйтэй холбоотой байна.

1.10 Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тодотголоор орлогын хэмжээг бууруулан баталсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр төвлөрөх орлого тасарч, Оюу толгой ХХК-ийн гэрээнд өөрчлөлт оруулснаар нэмэгдэж орох орлого тасарсантай холбоотой байна.

Хүний хөгжил сангийн орлогын бүрдүүлэлт хуулийн дагуу бүрэн төвлөрөөгүй байна.

1.11 “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай” хуулиар Хүний хөгжил санд 397.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 393.5 тэрбум

⁴ Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль, 2012.11.08-ны өдөр (<http://www.legalinfo.mn/law/details/8819?lawid=8819>)

төгрөг төвлөрч, төлөвлөгөө 1.0 хувиар буюу 4.0 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Үүнээс дээрх орлогод ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 325.0 тэрбум төгрөг, ногдол ашгаар 68.3 тэрбум төгрөг төвлөрчээ. Харин Хүний хөгжил сангаас санхүүжүүлсэн нийт зардлын хэмжээ 278.3 тэрбум төгрөг буюу төлөвлөсөн хэмжээнээс 1.6 хувиар буюу 4.5 тэрбум төгрөгөөр буурч биелсэн байна.

Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
			Дүн	Хувь
1. Нийт орлого	397,580.8	393,535.0	4,045.8	99.0
1.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	329,275.2	325,039.0	4,236.2	98.7
1.2. Хувьцааны ногдол ашиг	68,305.6	68,305.6	-	100.0
1.3. Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих \Банкны хүүгийн орлого\	-	190.4	-190.4	
2. Нийт зарлага	282,799.5	278,339.0	4,459.9	98.4
2.1 Төр хариуцах ЭМД-ын шимтгэл	12,151.5	12,151.5	-	100.0
2.2 Иргэдэд олгох бэлэн мөнгө	262,000.0	257,607.4	4,392.6	98.3
2.2.1. Хүүхдэд олгох мөнгө	234,000.0	228,994.3	5,005.7	97.8
2.2.2. Сар бүр олгох 21 мянган төгрөг	28,000.0	28,613.1	-613.1	102.1
2.3 Зээлийн үйлчилгээний төлбөр	8,648.0	8,580.3	67.7	99.2
2.4 Банкны үйлчилгээний хураамж	-	0.2	-0.2	
3. Ашиг, алдагдал	114,781.3	128,996.8	-14,215.5	112.3
4. Алдагдалыг санхүүжүүлэх эх үүсвэр	-114,781.3	-128,996.8	-14,215.5	112.3
4.1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-			
4.2. ХХСТХ-ийн 3.2.4-д заасан эх үүсвэр (Урьдчилгаа төлбөр)	-62,397.0	-76,540.2	-14,143.2	122.6
4.3. ЗГ-ын бонд	-52,384.3	-52,426.6	-42.3	100
4.3.1. Шинээр гаргах	55,715.7	55,673.4	-42.3	100
4.3.2. Үндсэн төлбөр	-108,100.0	-108,100.0	-	100

1.12 Хүний хөгжил сангаас 2013 онд төр хариуцах иргэний ЭМД-ын шимтгэлд 12.1 тэрбум төгрөг, 21.0 мянган төгрөгийг өмнөх онд аваагүй иргэдэд нөхөн олгоход 28.6 тэрбум төгрөг, Засгийн газрын бондын хүүгийн төлбөрт 8.5 тэрбум төгрөг, 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөгт 228.9 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ.

1.13 Хүний хөгжил сангийн 2013 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 1.0 хувиар, зарлага, санхүүжилт төлөвлөсөн хэмжээнээс 1.6 хувиар тасарсан байна. 2012 оны эцэст Нийгмийн даатгалын санд арилжсан Засгийн газрын бондын үндсэн төлбөр 108.1 тэрбум төгрөгийг төлж, шинээр 55.7 тэрбум төгрөгийн хямдруулсан үнэт цаасыг арилжааны банкуудад арилжаалсан байна.

1.14 Хүний хөгжил санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр төвлөрөх орлогыг 329.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөнөөс гүйцэтгэлээр 325.0 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 4.2 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар тасалжээ. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны болон өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөрийн хувьд дэлхийн зах зээлд гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ, тоо хэмжээний бууралтаас хамааран оны эхэнд төлөвлөж байсан хэмжээнээс буурсан байна.

1.15 2009-2012 оны уул уурхайн татварын орлогын гүйцэтгэл болон 2013 оны гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

2009-2013 онд Уул уурхайн салбараас Хүний хөгжил санд төвлөрсөн орлогыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Үзүүлэлт	Үүнээс ХХС-нд хуваарилагдах					Нийт
		2009	2010	2011	2012	2013	
1	АМНАТ	75.5	118.2	143.4	217.5	325.0	879.6
2	ӨННАТ**			124.4	88.9		213.3

3	Ногдол ашиг	-	-	78.9	141.2	68.3	288.4
4	Бусад						0.0
	БҮГД ДҮН	75.5	118.2	346.7	447.6	393.3	1,381.3

Хүний хөгжил санд 2013 онд “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-иас ногдол ашгийн орлого 68.3 тэрбум төгрөг төвлөрүүлжээ.

Зарим арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд олгох хүүгийн орлогын төвлөрүүлэлт зохих журмын дагуу хийгдээгүй байна.

1.16 2012 оны 1 дүгээр сарын 20-нд Сангийн дэд сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн дэд сайд (хуучнаар) арилжааны банкуудтай “Хүний хөгжил сан, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, хишиг хувийн мөнгийг иргэдэд олгох үйлчилгээний тухай” 3 талт гэрээг байгуулж, ХХС-аас иргэдэд хишиг хувь бэлнээр олгох ажлыг 2013 онд гэрээнд өөрчлөлт оруулахгүйгээр сунгаж, СХД, БЗД, СБД-ийн хувьд Хаан, Капитал, Төрийн банкаар дамжуулан гүйцэтгэсэн байна.

1.17 Гэтэл аудитад хамрагдсан СХД, БЗД, СБД-ийн НХҮХ гэрээний 4.1-д⁴ заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, сангийн дансны хүүгийн орлогыг сар, улирлын эцэст төвлөрүүлээгүй байна.

1.18 Харин ХХС-ийн үйл ажиллагаа дуусаж байгаатай холбогдуулан НХҮЕГ-аас 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 1/1326 дугаар албан тоотор санхүүжилтийн үлдэгдэл, хүүгийн болон бусад маягтын орлогыг ангилан тодорхой дансанд төвлөрүүлэх чиглэл өгснөөр дээрх 3 дүүргийн НХҮХ-үүд ХХС-ийн арилжааны банкин дахь данснаас 2013 оны 12 сард нийт 36.9 сая төгрөгийн хүүгийн орлогыг шилжүүлэн төвлөрүүлсэн байна.

1.19 Аудитын явцад дээрх 3 дүүргийн ХХС-ийн дансны дундаж үлдэгдэлд арилжааны банкууд хүү тооцсон эсэх, тооцоолол нь зөв эсэхийг шалгахад Капитал банкны 915 дугаар тооцооны төв Сангийн дэд сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн дэд сайд Капитал банктай байгуулсан 3 талт гэрээний 4.1-д заасныг зөрчин СБД-ийн ХХС-ийн харилцах дансны дундаж үлдэгдэлд 2012 оны 5 дугаар сараас 2013 оны 5 дугаар сар хүртэлх 12 сарын хугацаанд хүү тооцоогүй байна.

1.20 СБД-ийн НХҮХ гэрээний 5.3⁵-д заасныг зөрчин тооцоо нийлээгүй, хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүйгээс дээрх хүүгийн орлогыг тухай бүрт нь тооцож төвлөрүүлээгүй байна.

1.21 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар НХҮЕГ-т СБД-ийн ХХС-ийн зарим банкин дахь дансанд хүү тооцуулаагүй зөрчил гарсаныг Капитал банкаар нөхөж тооцуулан 4.6 сая төгрөгийн хүүгийн орлогыг авлагаар тусган тайлагнасан байна.

1.22 Мөн гэрээний 9.1⁶-д заасныг зөрчин 2014 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар хүүгийн орлогыг Капитал банкаар төлүүлээгүй байна. Түүнчлэн хүүгийн орлогыг зөв тооцон бүртгэсэн эсэхийг хянахад 2012 онд 3.4 сая, 2013 онд 1.7 сая, нийт 5.1 сая төгрөгийн хүү тооцох байсныг 0.5 сая төгрөгөөр дутуу тооцоолон бүртгэснийг төлүүлэхээр акт тогтоолоо.

⁵ “ХХҮХ нь Хүний хөгжил санаас санхүүжсэн хөрөнгийг үйлчилгээнд хамрагдсан иргэдэд тавьж олгосон жагсаалттай тулган нэг бүрчлэн хянаж, банкны тухайн салбар, тооцооны төвтэй сар бүр тооцоо нийлнэ”

⁶ “... банкны тухайн салбар тооцооны төвтэй сар бүр тооцоо нийлснээс гарсан зөрчил дутагдлыг НХҮЕГ-т мэдэгдэж дараа сарын 20-ны дотор шийдвэрлүүлнэ”

**БҮЛЭГ 2. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА**

2.1 Засгийн газрын 2010 оны 347 дугаар тогтоолын 3.3-д зааснаар Монгол банкин дахь Хүний хөгжил сангийн данснаас:

- Бэлэн мөнгөөр хүртээх хишиг, хувийн санхүүжилтийг аймаг, дүүргийн НХҮХ-ийн Хүний хөгжлийн сангаас арилжааны банкаар дамжуулан иргэний дансанд,
- Сургалтын төлбөр хэлбэрээр хүртээх хишиг, хувийн санхүүжилтийг Сургалтын төрийн сангийн дансанд,
- Эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр хүртээх хишиг, хувийн санхүүжилтийг аймаг, дүүргийн НДХ-ийн эрүүл мэндийн даатгалын сангийн дансанд тус тус шилжүүлэн олгохоор шийдвэрлэжээ.

2.2 Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан, бичиг баримтын зөрчилгүй тохиолдолд 2010 онд 120.0 мянга /70.0 мянга, 50.0 мянга/, 2011 онд жилд 252.0 мянга /сар бүр 21.0 мянга* 12 сар/, 2012 онд 128.0 мянга /5 сар* 21.0 мянга, 1 сар* 23.0 мянга/, нэг иргэнд нийт 500.0 мянган төгрөг бэлнээр олгогдсон байна. Мөн 2012 онд эмэгтэй 55, эрэгтэй 60 ба түүнээс дээш насны ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт 1,000.0 мянган /2 удаа*330.0 мянга, 1 удаа*340.0 мянга/ төгрөг нэмж олгосон байна. Иргэний бичиг баримт нь зөрчилтэй, бичиг баримтгүй, гадаад оронд оршин суугаа зэрэг шалтгаанаар иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй, өмнөх онуудад хишиг, хувиа авч чадаагүй иргэдэд нөхөн олгох, 18 хүртэлх насны хүүхэд бүрт сар тутам 20.0 мянган төгрөгийг 2013 онд аймаг, нийслэлийн ХХС-аас хишиг хувийг тус тус олгосон байна.

**Сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан зохих журмын
дагуу зарцуулсан байна**

2.3 “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль”, “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2012 оны 51 дүгээр тогтоол, Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгийг олгох журам”-ыг баримтлан Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө хэлбэрээр хишиг, хувь хүртээх үйл ажиллагааг зохион байгуулжээ.

2.4 “Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай” хуулиар дараах хэлбэрээр хишиг, хувь хүртээхээр баталсан байна. Үүнд:

- Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр,
- Бэлэн мөнгө.

Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийн талаар:

2.5 Хүний хөгжил сангаас 2013 онд Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт 12,151.5 сая төгрөг зарцуулсан байна. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх хэсэгт заасан “16 хүртэлх насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ 2 нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх, хугацаат цэргийн албан хаагч, нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Хүний хөгжил сангийн төсвөөс Эрүүл мэндийн даатгалын санд төлөхөөр хуульчилсан байна.

2.6 Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор Хүний хөгжил сангаас төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлд хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт		2013 он		
Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын төрөл		Даатгуулагчийн тоо	Шимтгэл-ийн хувь, хэмжээ	Санхүүжилт /сая төг/
Үүнээс:	16 хүртэлх насны хүүхэд	869,075	Сарын 670*, жилийн 8040 төгрөг	8,001.64
	Өндөр насны тэтгэвэр авагч	231,679		2,160.97
	Хүүхдээ асарч буй эх	56,011		436.49
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	57,676		404.63
	Хугацаат цэргийн албан хаагч	5,262		33.29
	Халамжийн тэтгэвэр авагч	29,135		234.34
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч	19,637		24.14
	Их дээд сургуулийн өдрийн ангийн суралцагч	120,439		855.96
НИЙТ ДҮН		1,388.914		12,151.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2013 оны тайлан

* ЭМД-ын шимтгэлийн 2013 оны хэмжээг тогтоосон (ЗГ-ын 2012 оны 195-р тогтоол)

2.7 Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан, мэдээгээр 16 хүртэлх насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагч, халамжийн тэтгэвэр авагч, их, дээд сургуулийн өдрийн ангийн суралцагчид нийт 1.3 сая иргэн Хүний хөгжил сангаас эрүүл мэндийн даатгалын шимтгэл хэлбэрээр нийт 12.1 тэрбум төгрөгийн хишиг, хувь хүртсэн байна.

2.8 Харин хишиг хувийг 1,000.0 мянган төгрөг болон өмнөх онуудад олгогдоогүй мөнгийг нөхөх хэлбэрээр бөөн дүнгээр олгогджээ.

Иргэдэд олгосон хишиг хувийг илүү бодитой, үр дүнтэй зүйлд зарцуулж болох байжээ

2.9 Хишиг хувь олголт нь 2010, 2011 онд хүнсний бараа бүтээгдэхүүн, 2012, 2013 онд хүнсний бус бараа үйлчилгээний зардлын өсөлтийг санхүүжүүлэхэд түлхүү зарцуулагдсан байх магадлалтайг статистик мэдээ болон иргэний хөдөлгөөний байгууллагаас авсан судалгааны дүнгээс харагдаж байна.

2.10 Тус байгууллагуудаас хийсэн судалгаанд оролцогчдын 82 хувь нь ажлын байр шинээр бий болгох, 90 гаруй хувь нь үйлдвэр, орон сууц, эмнэлэг, сургууль барихад ХХС-ийн хөрөнгийг зарцуулах нь зүйтэй гэсэн санал өгч байжээ.

2.11 Судалгааны дүгнэлтээр иргэд байгалийн баялгаас орж буй орлогыг ойр зуурын хэрэглээндээ бус ирээдүйдээ хөрөнгө оруулах, урт хугацаанд тогтмол орлого олох боломжтой ажлын байр бий болгох, үйлдвэр байгуулахад зарцуулах нь зүйтэй гэж үзжээ.

2.12 Аудитаар 2010-2013 онд нийслэлийн 9 дүүргийн ХХС-аас иргэдэд хишиг хувь олгоход зарцуулсан 494,100.0 сая төгрөгийг дараах чиглэлүүдэд хөрөнгө оруулахаар тооцвол тус бүр:

о 640 хүүхдийн суудалтай 200 гаруй сургууль²,

о 50 ортой 160 орчим төрөх эмнэлэг³,

о 100 хүүхдийн ортой 490 орчим цэцэрлэг⁴ барих,

о 1400 ажилтантай Дарханы төмөрлөгийн үйлдвэртэй адил хэмжээний 2 үйлдвэр байгуулж⁵ 2800 шинээр ажлын байр бий болгох боломж байжээ гэж дүгнэлээ.

² 640 хүүхдийн суудалтай 1 сургууль барилга барих өртөг 2,200.0 сая төгрөг

³ 50 ортой төрөх эмнэлгийн 1 барилга барихад дундажаар 3,000.0 сая төгрөг

⁴ 100 хүүхдийн ортой 1 цэцэрлэг барих төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг

⁵ Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хөрөнгийн хэмжээ 3,200.0 сая төгрөг

Бэлэн мөнгө олгосон талаар:

2.13 Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын мэдээгээр 2013 онд 960.279 хүүхдэд 20.0 мянган төгрөгийг олгоход нийт 228.9 тэрбум төгрөг, 21.0 мянган төгрөгийг нөхөж олгоход нийт 263.462 иргэнд 28.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.14 Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг тухайн гэр бүлийн орлогын түвшин нийгмийн байдлыг харгалзахгүйгээр тэгш олгох болон тодорхой нөхцөлтэйгээр олгох хэлбэрээр хэрэгжүүлсэн байна.

2.15 Хүний хөгжил сангийн тухай хууль нийгмийн халамжид чиглэсэн зардал, санхүүжилтийг хуульчилсан хэдий ч орлого бүрдүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж өгөөгүйгээс зарлага, санхүүжилт хийхэд байнга хүндрэл гарч байна.

2.16 Хүний хөгжил сангийн тухай хуулиар тус санд хуримтлагдсан хөрөнгийг гадаад, дотоодын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломжтой байхаар хуульчилсан боловч сангийн хөрөнгийг иргэдэд бэлэн мөнгө, сургалтын төлбөр, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр, орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртээхэд зарцуулж байгаа нь хуримтлал үүсгэж, баялгийн сангийн зарчмаар ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

2.17 Хүний хөгжил сангийн мөнгийг олгож эхэлснээс хойш мөнгөний нийлүүлэлт 2009 онд 2,880.0 тэрбум төгрөг байсан бол 2011 онд 6,427.2 тэрбум төгрөг болж өссөн байна. Харин 2008 онд зэсийн үнэ өндөр байснаас эдийн засагт тэлэлт нэмэгдэж энэ хэмжээгээр инфляци 22.1 хувь болж өссөн бөгөөд 2009 онд хямрал болсноор инфляци 4.2 хувь болон буурч улмаар Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож эхэлсэн 2010 онд 13 хувь, 2011 онд 10.2 хувь болж тус тус өссөн байна.

2.18 Бэлэн мөнгө олгох нь эдийн засгийн үр өгөөжтэй хөрөнгө оруулалтыг хязгаарлаж буй талаар нийгэмд нэгдсэн ойлголт бий болж байгаа энэ үед Хүний хөгжил сангийн тухай хуулийг Баялгийн сангийн тухай хууль болгон шинэчлэн боловсруулж уг сангийн үйл ажиллагааг гадаад орны туршлагыг судалсны үндсэн дээр сайжруулах шаардлагатай байна.

Хүний хөгжил сангийн өглөг авлагын талаар:

2.19 Хүний хөгжил сангийн төсвийн жил, сар, улирлын санхүүжилтийн дутууг “Хүний хөгжил сангийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.4, 3.4, Төв банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, Төсвийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.7-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа зээлийн санхүүжилт, тухайн онд төлөгдөх Засгийн газрын үнэт цаас гаргаж санхүүжүүлж, хүүгийн төлбөрт 2012-2013 оны хугацаанд 27.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.20 ХХС-аас 2010-2013 оны хугацаанд 2,228.8 сая төгрөгийн зарлага гарч энэ хугацаанд санд 1,306.0 сая төгрөгийн орлого төвлөрч стратегийн орд ашиглахтай холбоотой “Оюу Толгой” ХХК, “Эрдэнэс МГЛ” ХХК-аас авсан хүүтэй урьдчилгаа төлбөр, Засгийн газрын бондоор санхүүжүүлсэн байна.

ХХС-ийн 2013 өглөгийн байдлыг хүснэгтээр харуулбал:

Өгөг	Оны эхний үлдэгдэл			Оны эхнээс өссөн дүнгээр				Оны эцсийн үлдэгдэл				Тайлбар	
				Нэмэгдсэн		Буцаан төлсөн		Үлдэгдэл төлбөр		Тооцоот хүү*			Ханш 2013 12.30
	төгрөг	Ам.доллар	Ханш 2012.12.31	төгрөг	Ам.доллар	төгрөг	Ам.доллар	төгрөг	Ам.доллар				
ЗГ-ын бонд	479,034		1,392,101	55,673,411		108,100,000		426,083					
Урт хугацаатай (УБХБ, ХХБ)	205,000.00							205,000					313.1 тэрбум төгрөгийн урт хугацаат өглөг

Урт хугацаатай (Оюу Толгой ХХК)	165,934.00	100.00	1,392.10				165,410	100.00	20,855.3	12.61	1,654.10	ОТ-н 100 сая долларын бондын өглөг
Богино хугацаатай (НДЕГ)	108,100.00			55,673.41		108,100.00	55,673					313.1 тэрбум төгрөгийн богино хугацаат өглөг
Урьдчилгаа төлбөр	608,129.63	150.00	1,392.10			75,540.16	24,81	576,402				
Оюу Толгой	208,815.00	150.00	1,392.10			40,597.52	24,81	207,075	125.19	13,183.3	7.97	1,654.10
Таван толгой	399,314.63					35,942.64		363,371.99				
Улсын төсөв				5,955.31				5,955.31				ОТ-н урьдчилгаа төлбөрөөс татварын суутгалд хаахад УТ-д үүсгэсэн өглөг.
Нийт	1,087,163.68	250.00	1,392.10	61,628.72		184,040.16	24,81	1,002,485.41	225.19	34,038.51	20.58	

* Бондын хуримтлагдсан хүүг тооцохдоо энгийн жилийн 3 хувийн хүүтэйгээр урьдчилгаа төлбөрийн хуримтлагдсан хүүг тооцохдоо эхний 50 сая доллараас татварын суутган хасахаар, хүүг жил бүрээр нийлмэл хүүгийн аргаар тооцов.

2.21 ХХС-ийн өглөг 2013 оны эхэнд 608,129.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр, 250.0 сая ам.долларын бондын төлбөр байснаас оны эцэст 426,083.0 сая төгрөгийн ЗГ-ын бонд, 576,402.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр, 225.2 сая ам.долларын болон 34,038.5 сая төгрөгийн, 20.6 сая ам.долларын хүүний үлдэгдлийн өглөгийг төлөөгүй байна.

БҮЛЭГ 3. САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛ ХИЙЖЭЭ

3.1 Дотоод аудитын дүнд иргэнд олгосон бэлэн мөнгөний санхүүжилтийг хуваарилах явцад 2000 орчим иргэнд давхар санхүүжилт олгосон зөрчил илэрлээ. Тухайлбал, нийслэлийн Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн ХХҮГ-ын Хүний хөгжил сангийн үйл ажиллагаатай танилцахад нэр давхардсан бүртгэлээр 125 хүнд санхүүжилтийг олгосон бөгөөд зарим иргэнд давхар хувь хишиг хүртээсэн байна.

3.2 Сүхбаатар дүүргийн халамж үйлчилгээний хэлтсээс Арилжааны банкуудад хувь хишиг олгохоор илгээсэн файлаас 2012 оны 6 дугаар сарыг түүвэрлэн шалгахад 21 хүний мэдээлэл давхацсан байж болзошгүй гарсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газраас лавлагаа авахад эдгээр хүмүүс нэг хүн болох нь тогтоогджээ.

3.3 Эдгээр 21 харилцагчдад нийт 9,914.0 мянган төгрөг олгохоос тус дүүргийн ХХҮГ-аас 14,266.8 мянган төгрөгийг шилжүүлж 4,352.8 мянган төгрөг илүү олгосон байна.

3.4 Үүнээс ХХҮГ энэ оны 8-9 сарын хооронд 2,117.1 мянган төгрөгийг буцаан татсан бөгөөд иргэдэд 1,475.9 мянган төгрөг илүү олгогдсон байна.

3.5 Энэхүү давхардал зөвхөн тус 2 дүүрэгт биш системийн хэмжээнд регистрийн дугаарын зөвхөн нэг үсэг зөрүүтэй төрсөн он сар өдөр, олгосон дугаар, овог нэр бүгд адилхан 2000 орчим хүнд давхар хувь хишиг хүртээсэн байж болзошгүй байна.

3.6 Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт ашиглаж буй нэгдсэн портал бүхий програм хангамж нь зарим тохиолдолд файлыг алдаатай татах зөрчил ажиглагддаг боловч хариуцсан программистууд нь цаг тухайд нь Арилжааны банктай файлыг тохируулдаггүй нэг иргэнд давхар олгох боломжийг олгож байна.

3.7 Мөн зарим дүүргүүдэд олголтын файл, хаалтын файлын зөрүүг цаг тухайд нь тулгадаггүй, сарын сүүлд хаалтын файлыг нэг удаа авдаг зэрэг нь тухайн үйл ажиллагааг цалгардахад хүргэсэн байна. Энэхүү үйл ажиллагаа нь сонгосон 2 дүүрэгт ажиглагдаж байгаа хэдий ч бусад холбогдох 28 Хөдөлмөр халамжийн хэлтэст бүрэн давтагдах нь нийт зөрчилтэй иргэдийн мэдээлэлээс харагдаж байна.

3.8 Хүний хөгжил сангийн орлогын төлөвлөгөө төлөвлөлт, сар улирлын төсвийн хуваарь бодит байдалтай нийцэхгүй өндөр хэлбэлзэлтэй байна.

3.9 Батлагдсан төсвийн хуваарийн дагуу ТСГ-аас ХХҮГ-т болон ХХҮХ-ээс холбогдох арилжааны банкинд хөрөнгийг хуваарилахдаа эх үүсвэр хүрэлцэхгүй тохиолдолд ямар арга хэмжээ авах, яаж санхүүжүүлэх механизмын зохицуулалтыг үйл ажиллагааны журманд тусгаагүй, ямар нэгэн эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ АКТ, АЛБАН ШААРДЛАГА

Аудитад НХҮЕГ, Аймаг, нийслэлийн 22, Нийслэлийн 4 дүүргийн ХҮХ-ийг хамруулан 5 актаар 8.8 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр, 51.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж нөхөн олгуулахаар албан шаардлага өглөө. Үүнд:

Булган аймгийн НХҮХ

Хүний хөгжил сангаас олгосон эх орны хишиг, хувь хүртэх тэтгэмжийг олгохдоо хууль тогтоомж зөрчсөн ажлын хариуцлага алдсан зөрчилтэй холбогдуулан 3,811.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 31,199.0 сянган төгрөгийн албан шаардлага өглөө.

Дорноговь аймгийн НХҮХ

Аудитын явцад 2010 онд нас барсан нэг иргэний нэрийн дансанд шилжүүлсэн 1.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй байсанд төлбөрийн акт тогтоожээ.

Сүхбаатар аймгийн НХҮХ

НХҮХ-ийн мэргэжилтнүүд хүний хөгжил сангийн хишиг хувь олголтын мэдээлэлд тулгалт хийснээр нийт 49 иргэнд 2,998.0 мянган төгрөг илүү олгосон болохыг олж тогтоож, буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Гэсэн хэдий ч одоогийн байдлаар нийт 1,490.0 мянган төгрөгийг 18 иргэнээс буцаан төвлөрүүлээгүй байна. Иймд 1,490.0 мянган төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий иргэдээс буцаан төвлөрүүлж төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоосон байна.

Ховд аймгийн НХҮХ

НХҮХ-т гадаадын иргэн болсон 3 иргэнд хишиг хувь өгсөн нь баримтаар нотлогдож байгаа тул 1,290.0 төгрөгийн төлбөрийн актыг холбогдох иргэдээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоожээ.

Сэлэнгэ аймгийн НХҮХ

Жавхлант сум 2013 онд ХХС-аас олгосон хишиг хувь олголтын баримтыг аймгийн Аудитын газарт ирүүлж, аудит хийх нөхцөл боломжоор хангаагүй 15.7 сая төгрөг,

Цагааннуур, Шаамар суманд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний бичиг баримтын бүрдэл дутуу 2.0 сая төгрөг,

Сайхан суманд хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэний мөнгийг аймгийн НХҮХ-ийн буруугаас олгоогүй 3.0 сая төгрөг зэрэг нийт 20.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар тус тус албан шаардлага өгсөн байна.

Нийслэлийн НХҮХ

Хүүгийн орлогыг зөв тооцон бүртгэсэн эсэхийг хянахад 2012 онд 3.4 сая, 2013 онд 1.7 сая, нийт 5.1 сая төгрөгийн хүү тооцон авахыг 0.5 сая төгрөгөөр дутуу тооцоолон бүртгэснийг төлүүлэхээр акт тогтоосон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт хийхдээ гүйцэтгэлтэй холбоотой үүсэх эрсдэлийг тооцох асуудлыг анхаарч ажиллаагүй байна. Өөрөөр хэлбэл эрсдэлийг тооцоогүйгээс шинээр бонд, үнэт цаас гаргах зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа нь цаашид өр төлбөр өсгөх хандлага бий болгосон байна.
2. Сангийн хөрөнгийн орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөж чадахгүй байна.
3. Төсвийн төлөвлөлт бодит гүйцэтгэлээс ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь төлөвлөлтийг бодит биш төлөвлөж байгаатай холбоотой байна.
4. Хүний хөгжил сангийн мөнгөн хөрөнгийн орлогын дутагдлыг санхүүжүүлэх үүднээс бонд болон ЗГ-ын үнэт цаас гаргаж эх үүсвэр бүрдүүлсэн байна.
5. Хүний хөгжил сангийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх, Хүний хөгжил сангийн одоогийн тогтолцоог өөрчилж боловсронгуй болгох холбогдох хуулийн төслийг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажил хийгдээгүй байна.
6. Монгол улсад баялгийн сангийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр одоогийн зохицуулалтыг өөрчилж, баялгийн сангийн нийтлэг тогтолцоог бүрдүүлж, шинэчлэх ажил зогсонги байна.
7. ХХС-ийн татвар төлөгч байгууллагаас авсан урьдчилгаа төлбөр, ЗГ-ын ажиллагаанаас орсон орлогын хүүтэй төлж байгаа өглөгийг төлөх ажил удаашралтай байна.




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 25-02-47, <http://www.mof.gov.mn>

2014.06.25 № 7-3/3629
танай _____-ны № 858 -т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА**

"Хүний хөгжил сангийн 2013 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрч байна.

САЙД  Ч.УЛААН



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сангийн сайдад:

1. Төсвийн төлөвлөлт хийх механизмыг сайжруулж, Төсвийн төлөвлөлт хийхдээ гүйцэтгэлтэй холбоотой үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тооцож, орлогын төлөвлөлтийг хийхдээ улирлын шинж чанартай орлогын тасалдлыг нөхөх, зарлагыг хэрхэн санхүүжүүлэх талаар тодорхой эх үүсвэрийг тухайн жилийн Хүний хөгжил сангийн төсвийн тухай хуульд батлуулж байх;
2. Сангийн хөрөнгийн орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөх;
3. Хүний хөгжил сангийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэчлэх, Хүний хөгжил сангийн одоогийн тогтолцоог өөрчилж боловсронгуй болгох холбогдох хуулийн төслийг шинэчлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Баялгийн сангийн нэгдсэн тогтолцоог бий болгох;
5. ХХС-ийн татвар төлөгч байгууллагаас авсан урьдчилгаа төлбөр, хүүгийн өглөгийг төлж барагдуулах арга хэмжээ авах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсүгэй.

4. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хамжээ авч, үр дүнг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн сайд, Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД